

Журам батлах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.ж, 18.1.2.л, 18.2, Ашигт малтмалын тухай хуулийн 12.1 дэх заалтууд болон Засгийн газрын 2017 оны 151 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Бичил уурхайгаар олборлосон ашигт малтмал худалдан авах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Журмыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга нар болон холбогдох мэргэжлийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэ журам батлагдсантай холбогдуулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 05 сарын 09-ний өдрийн 70 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

С.СҮХБААТАР

БИЧИЛ УУРХАЙГААР ОЛБОРЛОСОН АШИГТ МАЛТМАЛ ХУДАЛДАН АВАХ АЖ АХУЙН НЭГЖИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол улсын Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ЖУРАМ”-аар тодорхой зохицуулагдаагүй бичил уурхай эрхлэгчдийн олборлосон ашигт малтмалыг худалдан борлуулах, ашигт малтмал худалдан авах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Аж ахуйн нэгжийн шалгуур үзүүлэлт, сонгон шалгаруулалт

2.1. Аймгийн Засаг даргын захирамжаар Бичил уурхай эрхлэгчдийн олборлосон ашигт малтмалыг худалдан авах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулна.

2.2. Тухайн сумын бичил уурхайгаас ашигт малтмал худалдан авах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах тухай албан хүсэлт ирсэн даруйд ажлын хэсэг ажлын 7 хоногт багтаан сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж, ажлын 10 хоногийн хугацаанд шийдвэрлэнэ.

2.3. Журмын 2.4 дэх заалтад заасан шалгуурыг хангасан 4 хүртлэх тооны аж ахуйн нэгжийг сонгоно.

2.4. Аж ахуйн нэгжид тавигдах шалгуур үзүүлэлт.

2.4.1. Аймгийн Татварын хэлтэст бүртгэлтэй

2.4.2. Тухайн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй

2.4.3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх туршлагатай байх /нөхөн сэргээсэн ажлын гэрээ, хүлээлгэн өгсөн акт, тайлан/

2.4.4. Татварын болон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр төлбөргүй байх

2.4.5. Хөрөнгө санхүүгийн чадвартай байх /санхүүгийн тайлан/

Гурав. Аймгийн Засаг даргын эрх, үүрэг

3.1. Бичил уурхайгаар олборлосон ашигт малтмалыг худалдан авах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, сумын Засаг дарга, нөхөрлөл, сонгогдсон аж ахуйн нэгжийн хооронд байгуулсан 3 талт хамтран ажиллах гэрээ баталж, хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.

3.2. Бичил уурхайн чиглэлээр сум болон нөхөрлөлийг удирдлага арга зүйгээр хангах, үйл ажиллагаа болон олборлосон ашигт малтмалаа худалдах, худалдан авах ажиллагаанд нь аймгийн Мэргэжлийн Хяналтын Газар болон мэргэжлийн бусад байгууллагуудаар дамжуулан Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих.

3.3. Ашигт малтмалын тээвэрлэлт хийж буй аж ахуйн нэгжүүдийг аймгийн “Ашигт малтмал тээвэрлэх замын маршрут”-ын дагуу тээвэрлэлт хийлгэж, хэрэгжилтэд хяналт тавих.

ДӨРӨВ. Сумын Засаг даргын эрх, үүрэг

4.1. Журмын 3.1-т заасан хамтран ажиллах гэрээ байгуулж, талууд худалдан авах ажиллагаа болон гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж буй эсэхэд байнгын хяналт тавих, гарсан зөрчил дутагдлыг таслан зогсоох.

4.2. Нөхөрлөлийн гишүүн бус хүн уурхай дээр ажиллаж буй эсэхэд хяналт тавьж, ажилласан тохиолдолд уг нөхөрлөлтэй хариуцлага тооцох.

4.3. Бичил уурхайчдын олборлосон ашигт малтмалыг худалдан авах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж өгөх тухай албан хүсэлтээ аймгийн Засаг даргад ирүүлэх.

4.4. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний дагуу нөхөрлөлүүдийг ажиллуулах.

4.5. Худалдан борлуулах ашигт малтмалыг баталгаат пүүгээр хэмжүүлсэн бичгийг үндэслэн, гарал үүслийн бичиг олгож, батлагдсан маршрутын дагуу тээвэрлэлт хийлгэх.

4.6. Худалдан борлуулахаар ачигдсан ашигт малтмалын татвар, хураамжийн тооцоог нарийвчлан хийх, нөхөрлөл болон аж ахуйн нэгжүүдээр анхан шатны бүртгэл хөтлүүлэх.

4.7. Худалдан авалт хийхээр сонгогдсон аж ахуйн нэгжийг Стандартын шаардлага хангасан жин хэмжүүр /пүү/-тэй ажиллахыг шаардах.

ТАВ. Бичил уурхайн нөхөрлөлүүдийн эрх, үүрэг

5.1. Журмын 3.1-т заасан хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах.

5.2. Олборлосон ашигт малтмалаа сонгогдож, гэрээ хийсэн аж ахуйн нэгжүүдэд худалдах бөгөөд тэдгээрийн аль өндөр үнээр авч байгаад нь олборлосон жоншоо борлуулах.

5.3. Олборлосон ашигт малтмалын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан, худалдан борлуулсан ашигт малтмалын хэмжээ, тооцооны анхан шатны бүртгэлүүдийг хөтлөх.

5.4. Нөхөрлөлийн гишүүн бус хүнийг талбай дээр ажиллуулахгүй байх.

ЗУРГАА. Худалдан авалт хийх аж ахуйн нэгжийн хүлээх эрх, үүрэг

6.1. Нөхөрлөлүүдийн олборлосон ашигт малтмалыг зөвхөн хамтран ажиллах гэрээ хийсэн аж ахуйн нэгж худалдан авах бөгөөд өөр аж ахуйн нэгж худалдан авалт хийхгүй, түүнд хяналт тавьж ажиллах.

6.2. Нөхөрлөлүүдийн олборлолт явуулах үйл ажиллагаанд болон нөхөн сэргээлтэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх.

6.3. Олборлолтын явцад хүний эрүүл мэнд, амь насанд аюултай байдал үүссэн тохиолдолд аваар ослыг арилгах арга хэмжээ авах, техник тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлэх.

6.4. Нөхөрлөлүүдийн олборлосон ашигт малтмалыг хамтран ажиллах гурвалсан гэрээнд заасан үнээс доошгүй үнээр худалдан авах.

6.5. Нөхөрлөлийн гишүүдэд хөдөлмөр, хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулж, хөдөлмөр хамгааллын багаж, хувцас, хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх.

6.6. Нөхөрлөлүүдээс худалдан авсан ашигт малтмалыг аймгаас тогтоосон тээвэрлэлт хийх зам, маршрутын дагуу тээвэрлэх, дотоод хяналтыг хэрэгжүүлэх.

6.7. Ашигт малтмалын нөөцийн болон бусад татвар хураамжийг цаг хугацаанд нь төлөх.

6.8. Мэргэжлийн геологич, уулын инженер, байгаль орчин, хөдөлмөр хамгааллын ажилтан тогтмол ажиллуулах.

6.9. Орон нутгийн төр захиргаа, хууль хяналтын байгууллага, нөхөрлөл, иргэдээс тавьсан хууль ёсны шаардлага, санал хүсэлтэд хүндэтгэлтэй хандаж, нөхөрлөлийн гишүүдтэй ёсзүйгүй харьцах, нийгмийн хэв журам зөрчихөөс сэргийлж ажиллах.

6.10. Нийгмийн хариуцлагын хүрээнд аймаг, сумын нийгмийн салбар /боловсрол, соёл, эрүүл мэнд/ -т хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын дэмжлэг үзүүлэх.

ДОЛОО. Хориглох зүйлс

7.1. Нөхөрлөлүүд аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулах, өөрсдөө тээвэрлэлт хийх.

7.2. Нөхөрлөлүүд олборлосон ашигт малтмалаа гэрээ байгуулсан аж ахуйн нэгжээс өөр этгээдэд борлуулах.

НАЙМ. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

8.1. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтан, нөхөрлөлийн гишүүн, аж ахуйн нэгжийг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.2. Гэрээ байгуулагч талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж үзвэл гэрээ байгуулсан нөгөө талдаа бичгээр мэдэгдэж, гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авч болно.

8.3. Бичил уурхай дээр онц ноцтой зөрчил гарсан тохиолдолд аймгийн Засаг дарга, мэргэжлийн болон хууль хяналтын байгууллага, сумдын удирдлагууд хамтран хэлэлцэж, бичил уурхайн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээ авна.

8.4. Бичил уурхай дээр осол аваар гарсан, хүний амь эрсэдсэн тохиолдолд буруутай үйл ажиллагаа явуулсан нөхөрлөл болон худалдан авалт хийхээр сонгогдсон аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг шууд цуцлана.

--oOo--